



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/673

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумдын газар зүйн нэрийн тодруулалт, баталгаажуулах ажил (Баян-Агт, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр)-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Вектормэп" ХХК-тай 408 900 000 (дөрвөн зуун найман сая есөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.


3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Вектормэп" ХХК-ийн захирал (Ш.Наран-Очир)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны  
09 дугаар сарын 25 ны өдрийн  
А/613 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Ажил гүйцэтгэх хугацаа	7 сар	Ү.Бямбасүрэн
2	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.	Д.Батцогт